



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ САЙДЫН
ТУШААЛ

2001 оны 7 дугаар
сарын 18-ны өдөр

Дугаар 397

Улаанбаатар
хот

Гадаадад суралцуулах тухай

2001-2002 оны хичээлийн жилээс өндөр хөгжилтэй орны их сургуулийн магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулсан мэргэжлийн комиссын дүгнэлт, "Өндөр хөгжилтэй орнуудад суралцагчдын асуудлаар санал, дүгнэлт гаргах комисс"-ын 2001 оны 7 дугаар сарын 18-ны өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Бадарч овогтой Батцэнгэлийг 2001-2002 оны хичээлийн жилээс Австрали улсын Баруун Австралийн Их сургуулийн магистрантурт олон улсын бизнесийн чиглэлээр 2 жилийн хугацаагаар суралцуулсугай.

2. Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайд, Санхүү, Эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дугаар хамтарсан тушаалаар баталсан "Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын дагуу суралцагчтай гэрээ байгуулж, холбогдох төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Б.Ганбат/, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Шинжлэх ухаан, технологи, дээд боловсролын бодлого, зохицуулалтын газар /М.Баасанжав/-т тус тус даалгасугай.

САЙД

B. Ganbat А.ЦАНЖИД